



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/481

Зуунмод

Ажлын хэсэг байгуулж зардал
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчдын хөдөлмөрийн онцлог, арга барилыг түгээн, туршлага солилцон, сурталчлан таниулах, уламжлалт сүү цагаан идээ боловсруулах соёлыг түгээх “Төв түмний сүүн соёл” сүүний баяр-2022 арга хэмжээ Батсүмбэр суманд 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Төв түмний сүүн соёл” сүүний баяр-2022 арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд шаардагдах 9,000,320 (есөн сая гурван зуун хорь) төгрөгийг Хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) нарт зөвшөөрсүгэй.

4. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэн, фермерийн аж ахуй эрхлэгчдийн ур чадварыг дээшлүүлэх, сүүний гарцыг нэмэгдүүлэх үндэсний уламжлалт сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д даалгасугай.

5. “Төв түмний сүүн соёл” сүүний баяр-2022 арга хэмжээний хүрээнд бялаг бүтээгчдийн борлуулалтыг дэмжиж “Төв түмний сүүн соёл” сүүний баяр-2022 арга хэмжээнд үхэрчид, саальчид, фермер аж ахуй эрхлэгч иргэн, хоршоологчдыг хамруулж баг бүрдүүлж оролцуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат), шилэн дансанд байршуулахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Б. Одончимэг

Сам хүү шил
ертөө

Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 23 -ны өдрийн А/481 дугаар захирамжийн 1 дугаар хавсралт




“ТӨВ ТҮМНИЙ СҮҮН СОЕЛ”
СҮҮНИЙ БАЯР-2022 АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт дүн
1.	Лэд дэлгэцийн түрээс	ш	1	2.000.000	2.000.000
2.	Хулдаасан хэвлэл, тайз засалт	м ²	106	12.000	1.272.000
3.	Цай, үдийн хоол	хүний тоо	200	8.000	1.600.000
4.	Шилдэг сум 1-р байр мөнгөн шагнал	тоо	1	1000.000	2.300.000
	Шилдэг сум 2-р байр мөнгөн шагнал	тоо	1	800.000	
	Шилдэг сум 3-р байр мөнгөн шагнал	тоо	1	500.000	
5.	Цагаан идээ боловсруулах арга туршлага солилцох бичлэг бэлтгэх	тоо	1	1.392.000	1.392.000
6.	Хүндэтгэлийн гэр зөөх барих, машин шатахуун Зуунмод-Батсүмбэр-Зуунмод-480км Майти 240x0,30=72 Стрикс 240x0,15=36 3x0.16=52	км	108	4040	436.320
НИЙТ ДҮН					9.000,320

Ангуу

Оюун

Ник



ТООЦСОН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* Ж.БАТЧИМЭГ

ХЯНАСАН:
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* Ч.ЦЭЦЭГСҮРЭН